



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ихтамир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/002/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор **А.Пүрэвцэцэг**
Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ОРОЛМУУ ТАНАА

2026.03.24 № 156
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Ихтамир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг тулган шалгахад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 12,542,451 төгрөгийг санхүүгийн тайланд бүргээгүй байна.
2. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 507,245.6 мянган төгрөгөөр давуулсан боловч хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг төлөвлөснөөс 6,568.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
3. Ихтамирын хөгжил дэд бүтэц” ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнийн тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөөс нийт 177,409,302 төгрөгийн халаалтын орлогыг төвлөрүүлсэн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3,

Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3,614,115.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,842,545.8 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 771,569.5 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Энэ нь ОНХС, ХХС-нд төлөвлөснөөс 348,956.2 мянган төгрөг зарцуулагдаагүй, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 266,680.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, 155,932.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу хийгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 65.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,476,326.11	1,836,152.75
31	Мөнгөн хөрөнгө	1,083,140.15	1,313,478.15
33	Авлага	314,097.97	407,521.59
34	Урьдчилгаа	10,400.00	-
35	Бараа материал	25,148.00	45,048.00
36	Нөөцийн бараа	43,540.00	70,105.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,360,195.29	4,799,476.43
39	Үндсэн хөрөнгө	4,360,195.29	4,799,476.43
39200	Биет хөрөнгө	4,315,600.46	4,755,736.60
39300	Биет бус хөрөнгө	44,594.83	43,739.83
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	5,836,521.40	6,635,629.18
4	Нийт өр төлбөр	-	33,891.04
41	Богино хугацаат өр төлбөр		33,891.04
	Өглөг		33,891.04
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,836,521.40	6,601,738.14
51	Засгийн газрын хувь оролцоо	5,836,521.40	6,601,738.14
512	Засгийн газрын оруулсан капитал	627,640.14	627,640.14
51200	Хуримтлагдсан үр дүн	4,542,111.20	5,307,327.94
51210	Өмнөх үеийн үр дүн	3,755,858.79	4,531,711.20
51220	Тайлант үеийн үр дүн	786,252.41	775,616.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	666,770.07	666,770.07
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 6=4+5	5,836,521.40	6,635,629.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,505,956.16	3,900,731.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,021,715.83	1,066,740.67
110	Орлогын албан татвар	758,414.79	633,101.41
1100	Хувь хүний орлогын албан татвар	758,236.29	684,485.93
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-51,824.08
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	178.5	439.56
113	Хөрөнгийн албан татвар	91,025.07	203,131.06
118	Бусад татвар, төлбөр, хураамж	172,275.97	230,508.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	677,505.52	2,833,990.37
120	Нийтлэг татварын бус орлого	855,135.52	1,054,946.14
122	Тусламжийн орлого	0	4,753,742.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,806,734.81	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,205,159.97	2,997,266.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,205,159.97	2,977,266.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044,732.45	2,823,995.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	893,533.63	1,064,771.05

Архангай аймгийн Ихтамир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,158.47	135,157.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	418,409.32	526,053.16
2104	Хангамж, бараа материалын зардал	69,684.02	81,842.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,299.40	62,990.36
2107	Томилолт, зочны зардал	15,924.50	13,720
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,441.46	494,634.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,281.66	444,826.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,427.52	153,271.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	20,000
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,300,796.19	903,464.49
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	514,543.78	127,847.76
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-514,543.78	-127,847.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	786,252.41	775,616.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,242,814.38	3,479,007.42
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,021,715.83	1,066,740.67
110	Орлогын албан татвар	758,414.79	633,101.41
1100	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-51,824.08
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	178.5	439.56
113	Хөрөнгийн албан татвар	91,025.07	203,131.06
118	Бусад татвар, төлбөр, хураамж	172,275.97	230,508.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,365.64	48,160.64
1181	Газрын төлбөр	4,866.22	2,463.32
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	144,044.11	179,884.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	414,363.73	2,412,266.75
120	Нийтлэг татварын бус орлого	414,363.73	483,322.52
122	Тусламжийн орлого	0	1,647,651.47
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	281,292.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,806,734.81	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,089,827.59	2,674,016.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,089,827.59	2,674,016.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,919,000.07	2,520,745.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	893,533.63	1,125,720.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,158.47	135,157.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	418,409.32	542,177.21
2104	Хангамж, бараа материалын зардал	70,104.02	138,081.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,672.4	63,321.86
2107	Томилолт, зочны зардал	15,924.50	13,720
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,381.57	346,900.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,816.17	155,666.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,827.52	153,271.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,152,986.78	804,990.96

Архангай аймгийн Ихтамир сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	584,338.15	404,652.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	584,338.15	404,652.96
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-584,338.15	-404,652.96
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000	170,000
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-20,000	-170,000
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	548,648.63	230,338.01
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	534,491.52	1,083,140.15
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,083,140.15	1,313,478.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,050,268.99	5,050,268.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,050,268.99	5,050,268.99
9	Тайлант үеийн үр дүн	786,252.41	786,252.41
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,836,521.40	5,836,521.40
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,836,521.40	5,836,521.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-10,400	-10,400
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,826,121.40	5,826,121.40
19	Тайлант үеийн үр дүн	775,616.74	775,616.74
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,601,738.14	6,601,738.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦЭВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,023,067.80	1,372,653.89	(349,586.09)	134.17
11	Татварын орлого	777,658.40	1,066,740.67	(289,082.27)	137.17
12	Татварын бус орлого	245,409.40	305,913.22	(60,503.82)	124.65
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,614,115.30	2,842,545.85	771,569.45	78.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,544,845.20	2,305,298.10	239,547.10	90.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,476,159.60	2,257,235.28	218,924.32	91.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,072,735.80	1,064,771.05	7,964.75	99.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,980.60	132,334.06	1,646.54	98.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	567,999.10	526,053.16	41,945.94	92.62
2104	Хангамж, бараа материалын зардал	82,120.00	65,845.95	16,274.05	80.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115,860.00	96,838.76	19,021.24	83.58
2107	Томилот, зочны зардал	16,894.70	13,720.00	3,174.70	81.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	318,269.40	235,653.21	82,616.19	74.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,300.00	122,019.09	46,280.91	72.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,685.60	48,062.82	20,622.78	69.98
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,500.00	-	13,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,185.60	48,062.82	7,122.78	87.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	834,066.80	367,247.76	466,819.04	44.03
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	235,203.30	170,000.00	65,203.30	72.28
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	71.00	71.00	-	100.00
61	Байгууллагын тоо	3.00	3.00	-	100.00
62	Ажиллагсадын тоо	34.00	34.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	247,511.17
1221	Хандив тусламж /дотоод/	247,511.17
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,302.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,302.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,302.92
2104	Хангамж, бараа материалын зардал	2,280.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,888.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,486.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,647.45
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	105,208.25

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй 211,746.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 4 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 211,746.9 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн 17,427,7 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **229,174.6** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **25,98.8** мянган төгрөгөөс их, мөн Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнийн тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр “Ихтамирын хөгжил дэд бүтэц” ОНӨААТҮГ байгуулсныг тус тус үндэслэн **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг төлөвлөснөөс нийт 6,568.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2 “Ихтамирын хөгжил дэд бүтэц” ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнийн тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөөс нийт 177,409.3 мянган төгрөгийн халаалтын орлогыг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн "Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох" 12.1.2-т "12.1.2.дулаан үйлдвэрлэх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэж, эрчим хүчний эх үүсвэрийг цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох эрх олгоно", 13.2-т "13.2.Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан худалдах үнэ, нөхцөлийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор хянуулж батлуулна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: ОНӨААТҮГ-ыг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэх

3.1.3 Иргэдийн саналгүй 15,226.6 мянган төгрөгийн наадмын талбайд худаг гаргах төсөл арга хэмжээг баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", 4.7.5-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.1.4 Тайлант оны Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг тулган шалгахад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 12,542.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүргээгүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 10 дугаар зүйлийн 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг таслан зогсоож, хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулан, хүүгийн авлагыг санхүүгийн тайланд тухай бүр бүртгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлоготой холбоотой	1	6,568.6	-	-	1	6,568.6			-	-	-	-
ОНӨААТҮГ	1	177,409.3			1	177,409.3						
ХХС	1	12,542.4			1	12,542.4						
ОНХС	1	15,226.6			1	15,226.6						
НИЙТ ДҮН	4	211,746.9	-	-	4	211,746.9			-	-	-	-

5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	17,227.7			4	17,227.7						
ИТХ	3	200.0	1	200.0	2						-	-
Дүн	7	17,427.7	1	200.0	6	17,227.7						